

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
сайдын 2019 оны ... дугаар сарынөдрийн
.....дүгээр тушаалын хавсралт

ГОЙД АШИГ ШИМТ МАЛ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үндэсний хэмжээнд өсгөн үржүүлж буй хянан баталгаажсан үүлдэр, омгийн мал болон тухайн бүс нутагт нутагшуулан 5 ба түүнээс доошгүй жил үржүүлж буй эрлийз, бусад үүлдрийн малыг гойд ашиг шимт малаар сонгон шалгаруулахтай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна;

1.2. Гойд ашиг шимт шилмэл малыг итгэмжлэл, зэрэг дэв бүхий мэргэжлийн шинжээчдийн явуулсан үзлэг ангилалтын үзүүлэлтийг үндэслэн удам зүйн үнэлгээний программ (цаашид “Программ” гэх)-д бүртгэгдсэн мал /адуунаас бусад/-ыг шалгаруулна. Баталгаажсан үүлдэр, үүлдрийн болон үржлийн хэсэг, омгийн 2 наст болон түүнээс дээш насны, нутагшуулан үржүүлж буй эрлийз малын төрөл, зүйл, биеийн үндсэн хэмжээ, ашиг шимийн түвшингээс хамааран шилмэл болон гойд ашиг шимт мал гэж тодорхойлно.

1.3. Программд бүртгэгдсэн малаас гойд ашиг шимт мал шалгаруулах, улсын бүртгэл, үржлийн дэвтэр хөтлөхөд энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Гойд ашиг шимт шилмэл мал сонгон шалгаруулахад тавих шаардлага

2.1. Улс, аймаг, сум, дүүрэгт сонгон шалгаруулах шилмэл мал нь ангилалтын шаардлагын дагуу хувийн дугаар тавигдсан, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн байна;

2.2. Гойд ашиг шимт малаар шалгаруулах мал нь программд бүртгэгдсэн, ашиг шим, биеийн үндсэн үзүүлэлтээрээ тухайн үүлдэр, үүлдрийн болон үржлийн хэсэг, омгийн малын стандартын шаардлагаас 15-аас доошгүй хувиар илүү байна;

2.3. Гойд ашиг шимт малаар нутгийн болон нутагшсан, эрлийз малыг амьдын жин, ноос, ноолуурын гарцаар, үржлийн тэмээ, үхэр, хонь, ямааг 2 настайд нь, сүүний гарцаар үнээ, ямааг 6, ингэн тэмээг 8 настайд нь тус тус сонгон шалгаруулна;

2.4. Сүүний гарцаар шалгарах нутгийн болон нутагшсан, эрлийз үүлдрийн ингэ, ямаа, сүүний болон сүү-махны үүлдрийн үнээ нь төллөх насандаа төллөж, төл нь 100 хувь бойжсон байх бөгөөд саамын гарц нь саалийн дараалсан хоёр жил программд бүртгэгдсэн байна;

2.5. Хурдны чиглэлийн гойд ашиг шимт монгол адууг шалгаруулахдаа сум, аймгийн баяр наадамд айрагдсан адуунаас шилмэл, улс, бүсийн баяр наадамд түрүү, аман хүзүүнд ирсэн адуунаас гойд ашиг шимт малаар шалгаруулна.

2.6. Улсад шалгарсан гойд ашиг шимт малыг малын эзэн зохих хууль, журмын дагуу даатгуулна;

2.7. Малын халдварт болон гоц халдварт өвчнөөс эрүүл болох нь мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээгээр нотлогдсон байх;

Гурав. Гойд ашиг шимт шилмэл малыг бүртгэж, үржлийн дэвтэрт хөтлөх

3.1. Малын генетик нөөцийн тухай хуулийн 18.2.3 дахь заалтыг үндэслэн жил бүр гойд ашиг шимт мал шалгаруулж, улсын бүртгэл, үржлийн дэвтэрт хөтлөнө;

3.2. Гойд ашиг шимт малыг үржлийн дэвтэрт бүртгэх ажлыг аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллагын Мал үржлийн албанаас оруулсан

мэдээллийг үндэслэн улсын хэмжээнд малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүтцэд байх асуудал хариуцсан мэргэжилтэн гүйцэтгэнэ;

3.3. Программд үндэслэн мал нэг тус бүрт үнэлгээ өгөх хэлбэрээр зохион байгуулж бүртгэнэ;

3.4. Гойд ашиг шимт малыг сум, дүүрэгт дор дурдсан хугацаанд жил бүр шалгаруул, үржлийн дэвтэрт бүртгэнэ;

3.4.1.ноосны гарцаар тэмээ, хонийг 5, 6 дугаар сард;

3.4.2.ноолуурын гарцаар ямааг говь, тал хээрийн бүсэд 3, 4, хангайн бүсэд 4, 5 дугаар сард;

3.4.3.амьдын жингээр 5 төрөл /адуу, үхэр, тэмээ, хонь, ямаа/-ийн малыг хавар 5 дугаар сард, намар 10 дугаар сард;

3.4.4.сүүн ашиг шимээр шалгаруулах малыг саалийн хугацаанд өгсөн саамын нийт үзүүлэлтээр;

3.5. Улсын хэмжээнд гойд ашиг шимт малыг нэгдсэн байдлаар шалгаруулахдаа бол сум, мал бүхий дүүргээс ирүүлсэн нэгдсэн дүн, тодорхойлолтыг үндэслэн 9, 10 дугаар сард зохион байгуулж, шалгаруулна;

3.6. Сум, мал бүхий дүүрэг, аймаг, улсад шалгарсан гойд ашиг шимт шилмэл малыг бүртгэж, үржлийн дэвтэрт бүртгэнэ;

Дөрөв. Гойд ашиг шимт мал шалгаруулах ажлыг зохион байгуулах

4.1. Гойд ашиг шимт мал сонгон шалгаруулах ажлыг жил бүр сум, мал бүхий дүүрэг, аймаг, улсын хэмжээнд зохион байгуулж, хэрэгжүүлнэ;

4.2. Гойд ашиг шимт 5 хошуу малыг шалгаруулахдаа дараах түвшинд зохион байгуулна.

2.2.1.сум, мал бүхий дүүрэгт “Сум, дүүргийн гойд ашиг шимт мал”;

2.2.2.аймагт “Аймгийн гойд ашиг шимт мал”;

2.2.3.улсад “Улсын гойд ашиг шимт мал”;

4.3. Сум, дүүрэг, аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллагын мал үржлийн алба, хуулийн этгээд харъяалах нутаг дэвсгэрийнхээ малын ашиг шим, шинж тэмдгийн үзүүлэлтийг үндэслэн программд бүртгэгдсэн малыг шалгаруулна;

4.4. Сум, дүүрэг, аймаг, улсын хэмжээнд гойд ашиг шимт мал сонгон шалгаруулах ажлын хэсгийг аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллагын мал үржлийн алба, Засаг даргын тамгын газрын ажилтан, хөдөө аж ахуйн тасаг, мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгж /цаашид “үйлчилгээний нэгж” гэх/ болон ивээн тэтгэгчдийн төлөөллийг оролцуулан тухайн шатны Засаг дарга томилно;

4.5. Гойд ашиг шимт шилмэл мал шалгаруулах тов, байршлыг зохион байгуулах ажлын хэсэг 15-аас доошгүй хоногийн өмнө зарлан мэдээлнэ;

4.6. Улсын хэмжээнд гойд ашиг шимт мал шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлана;

Тав. Улсын бүртгэл, үржлийн дэвтэрт тавигдах шаардлага

5.1. Улсын бүртгэл, үржлийн дэвтэр нь үнэт цаасанд хэвлэгдсэн, бүртгэгчийн гарын үсэг, нууцлалтайгаар бусад дэвтрээс ялгагдан үнэт чанараа хадгална;

5.2. Гойд ашиг шимт малаар шалгарч бүртгэгдсэн малын фото зургийг 13x18 хэмжээтэй хэвлэж зурган файлын хамт тухайн жилийн 12 сарын 01-ний өдрөөс өмнө багтаан Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаын бүтцэд байх асуудал хариуцсан мэргэжилтэнд хүргүүлж үржлийн дэвтэрт хавсаргана;

5.3. Улсын бүртгэл, үржлийн дэвтэрт жил бүр бүртгэгдсэн малын мэдээлэл, фото зургийг программд байршуулж, архивийн нэгж болгон хадгалах ба малын удам зүйн үнэлгээний системийн www.muz.gov.mn цахим хуудсанд байршуулна;

Зургаа. Малын эзэн, гойд ашиг шимт малыг шагнаж урамшуулах

6.1. Сум, дүүрэг, аймагт шалгарсан гойд ашиг шимт малын эзэн, уг малыг илрүүлэн шалгаруулсан мэргэжилтэн нарт олгох шагналын хэмжээг тухайн шатны Засаг дарга тогтоож, шаардагдах зардал, хөрөнгийг шийдвэрлэнэ;

6.2. Улсад шалгарсан гойд ашиг шимт малын эзэнд гэрчилгээ олгох бөгөөд дээр заасан мөнгөн шагналын зардлыг Малын генетик нөөцийн тухай хуулийн 10.8 дахь хэсгийг үндэслэн энэ журмын 6.3-д заасны дагуу Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж олгоно;

6.3. Улсад шалгарсан гойд ашиг шимт малын эзэн, илрүүлэн шалгаруулсан мэргэжилтэнд дор дурдсан хэмжээний шагналыг малын толгой тутамд тооцож нэг удаа олгоно;

6.4. Олгох шагналын доод хэмжээ;

6.4.1.гойд ашиг шимт тэмээ

д/д	Шалгаруулалтын төрөл	Шагналын төрөл	Шагнал олгох тоо	Олгох шагнал			
				Тууз	Зүүлт	Батламж	Олгох мөнгөн дүн
1	Гойд ашиг шимт буур	Тэргүүн байр	1	1	1	1	350000
		Дэд байр	1	1	1	1	250000
2	Гойд ашиг шимт ингэ	Тэргүүн байр	1	1	1	1	350000
		Дэд байр	1	1	1	1	250000
3	Тусгай байр		1	0	0	1	200000

6.4.2.гойд ашиг шимт адуу

д/д	Шалгаруулалтын төрөл	Шагналын төрөл	Шагнал олгох тоо	Олгох шагнал			
				Тууз	Зүүлт	Батламж	Олгох мөнгөн дүн
1	Гойд ашиг шимт азарга	Тэргүүн байр	1	1	1	1	350000
		Дэд байр	1	1	1	1	250000
2	Гойд ашиг шимт гүү	Тэргүүн байр	1	1	1	1	350000
		Дэд байр	1	1	1	1	250000
3	Тусгай байр		1	0	0	1	200000

6.4.3.гойд ашиг шимт үхэр

д/д	Шалгаруулалтын төрөл	Шагналын төрөл	Шагнал олгох тоо	Олгох шагнал			
				Тууз	Зүүлт	Батламж	Олгох мөнгөн дүн
1	Сүүний чиглэлийн гойд ашиг шимт хээлтэгч	Тэргүүн байр	1	1	1	1	350000
		Дэд байр	1	1	1	1	250000
		Тусгай байр	1	0	0	1	200000
2	Сүүний чиглэлийн гойд ашиг шимт хээлтүүлэгч	Тэргүүн байр	1	1	1	1	350000
		Дэд байр	1	1	1	1	250000
3	Махны чиглэлийн гойд ашиг шимт хээлтэгч	Тэргүүн байр	1	1	1	1	350000
		Дэд байр	1	1	1	1	250000
4	Махны чиглэлийн гойд ашиг шимт хээлтүүлэгч	Тэргүүн байр	1	1	1	1	350000
		Дэд байр	1	1	1	1	250000

6.4.4.гойд ашиг шимт хонь

д/д	Шалгаруулалтын төрөл	Шагналын төрөл	Шагнал олгох тоо	Олгох шагнал			
				Тууз	Зүүлт	Батламж	Олгох мөнгөн дүн
1	Нарийн, нарийвтар ноост хонины гойд ашиг шимт хээлтэгч	Тэргүүн байр	1	1	1	1	350000
		Дэд байр	1	1	1	1	250000
2	Нарийн, нарийвтар ноост хонины гойд ашиг шимт хээлтүүлэгч	Тэргүүн байр	1	1	1	1	350000
		Дэд байр	1	1	1	1	250000
3	Ширүүн, ширүүвтэр ноост хонины гойд ашиг шимт хээлтэгч	Тэргүүн байр	1	1	1	1	350000
		Дэд байр	1	1	1	1	250000
4	Ширүүн, ширүүвтэр ноост хонины гойд ашиг шимт хээлтүүлэгч	Тэргүүн байр	1	1	1	1	350000
		Дэд байр	1	1	1	1	250000
5	Гойд ашиг шимт хонины тусгай байр		1	0	0	1	200000

6.4.5.гойд ашиг шимт ямаа

д/д	Шалгаруулалтын төрөл	Шагналын төрөл	Шагнал олгох тоо	Олгох шагнал			
				Тууз	Зүүлт	Батламж	Олгох мөнгөн дүн
1	Ноолуурын ямааны гойд ашиг шимт хээлтэгч	Тэргүүн байр	1	1	1	1	350000
		Дэд байр	1	1	1	1	250000
2	Ноолуурын ямааны гойд ашиг шимт хээлтүүлэгч	Тэргүүн байр	1	1	1	1	350000
		Дэд байр	1	1	1	1	250000
3	Сүүний ямааны гойд ашиг шимт хээлтэгч	Тэргүүн байр	1	1	1	1	350000
		Дэд байр	1	1	1	1	250000
4	Гойд ашиг шимт хонины тусгай байр		1	0	0	1	200000

Долоо. Гойд ашиг шимт малын удмын санг хамгаалах, үржилд ашиглах

7.1. Улс, аймаг, сум, мал бүхий дүүрэгт шалгарсан гойд ашиг шимт малыг тухайн бүс нутгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллагын мал үржлийн алба хяналтад авч, үржил селекцийн ажлыг тодорхой чиглэлээр ашиглан үржүүлнэ;

7.2. Улсад гойд ашиг шимтээр шалгарсан хээлтэгч, хээлтүүлэгчийн үр төлийг үржлийн зориулалтаар худалдан борлуулах, зохиомол хээлтүүлэгт ашиглах, үр, хөврөл үрийг нь генийн санд хадгалах ажлыг Малын удмын сангийн үндэсний төв хариуцан гүйцэтгэнэ;

7.3. Гойд ашиг шимт малыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, тэдгээртэй холбоотой хуанли, зурагт хуудас, сэтгүүл, товхимол хэвлүүлж түгээх, мэдээлэхэд тухайн шатны Засаг дарга, Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага давуу эрхтэй байна;

.....о О о.....